



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар

1499

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны
Энхийн санаа өрхийн эрүүл мэндийн
төвийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны Энхийн санаа өрхийн эрүүл мэндийн төвийн эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 12,955,838.00 (арван хоёр сая есөн зуун тавин таван мянга найман зуун гучин найм) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн Энхийн санаа өрхийн эрүүл мэндийн төв (Х.Нацаг)-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 6 нэр төрлийн 3,205,788.00 (гурван сая хоёр зуун таван мянга долоон зуун наян найм) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгах, 3 нэр төрлийн 9,750,050.00 (есөн сая долоон зуун тавин мянга тавь) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг хоёрдогч түүхий эдийн зориулалтаар 50,000.00 (тавин мянга) төгрөгөөр худалдан борлуулж, орлогын 30 хувь болох 15,000.00 (арван таван мянга) төгрөгийг нийслэлийн Өмчийн харилцааны газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд шилжүүлэхийг Сүхбаатар дүүргийн Энхийн санаа өрхийн эрүүл мэндийн төв (Х.Нацаг)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.Оюумаа

В.ОЮУМАА

1150501200

Нийслэлийн Өмчийн харилцаа
даргын 2024 оны ... дүгээр са
өдрийн *А.Б.Б.* дугаар тушаалын

СБД-ийн 09-р хорооны "Энхийн санаа" Өрхийн эрүүл мэндийн төв 2024 он

[illegible]